



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 20 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Дугаар 106

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/, Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/ нарт даалгасугай.
3. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөг батлах тухай” 2002 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын 22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэ тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР
